

Ажлын байрандаа аливаа дарамтлалд өртөж байна уу?

Ажлын байран дээр дарамтлах нь хүлээн зөвшөөрөгдөхгүй үйлдэл юм. Хэрэв та ийм байдалд өртсөн бол холбоо барина уу.



Ажилчныг иргэншил (Япон ба гадаад), оршин суух статусаар ялгаварлаж* дарамтлахыг хүлээн зөвшөөрч болохгүй!

* Ажлын байранд жишээлбэл, томиллолтоор явах газар, албаны машин, бизнесийн туншүүдтэй уулзах газрууд орно.

Жишээлбэл доорх үйлдлийг хэлнэ:

Эрх мэдлийн дарамт

Биед гар хүрэх

Зодох, өшиглөх

Хэтрүүлж шаардах

Хийх ёстой ажил биш байтал гадаад хэлний орчуулга хийхийг шаардах

Хувь хүн руу чиглэсэн халдлага

Эх орны байдал, соёлыг доромжлох

Сэтгэцийн халдлага

Хамт олныхоо өмнө "Ийм энгийн япон үг ч мэдэхгүй гэж үү!" гэж хашгирч доромжлох

Үл тоомсорлох

Ямар ч ажил хийлгэдэггүй

Харилцаанаас салгах

Хамтран ажиллагсад, дарга нар үл тоомсорлох

Бэлгийн дарамт

Дарга миний бэлхүүс, цээжинд хүрч, эсэргүүцсэн чинь зүй бусаар намайг өөр ажилд томилсон.

Дарга хамтдаа хоол идэх, болзохыг тулган шаардаж, сэтгэл санааны даралттай байдгаас болж ажилдаа явах дургүй болсон.

Жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах чөлөө авах гэх мэт үед дарамтлах

Жирэмсний амралтаа авах талаар даргатайгаа зөвлөлдөхөд "Чи амрах бол ажлаасаа гарах хэрэгтэй" гэж хэлсэн.

Даргатайгаа илүү цагаар ажиллахаас чөлөөлөх талаар зөвлөлдөхөд "Дараагийн үнэлгээнд дэвшинэ гэж битгий бодоорой" гэж хэлсэн.

Дарамт шахалтанд өртсөн үед хэрхэх тухай мэдээлэл авах, зөвлөгөө өгөх газартай холбогдохыг хүсвэл арын хуудаснаас үзнэ үү.

Түүнчлэн.....

Жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах чөлөө авсан гэх мэт шалтгаанаар танд зүй бусаар хандсан бол товхимолоос үзэж дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.

Хэрэв та дарамт шахалтанд өртсөн бол

Үзэл бодлоо тод илэрхийлэх

Дуугүй тэвчээд өнгөрөх нь нөхцөл байдлыг улам дордуулж болзошгүй юм.

“Болиоч”, “Надад таалагдахгүй байна” гэж өөрийн үзэл бодлоо тод илэрхийл.

Ажлын газрын зөвлөх хэсэгтэй холбогдож зөвлөгөө авах

Дарамт шахалт бол хувь хүний асуудал биш байгууллага нийтийн асуудал юм. Ажлын газрын боловсон хүчин, хөдөлмөрийн асуудал хариуцсан хүн эсвэл итгэж болох даргатайгаа ярилцаж зөвлөгөө аваарай.

Хэрэв ажлын газар дээр зөвлөлдөхөд хүндрэлтэй, эсвэл зөвлөлдсөний дараа сайжрахгүй бол Нийслэл, мужийн хөдөлмөрийн товчоо гэх мэт гадны байгууллагад* д хандана уу.

* Зөвлөгөө өгөх газарт хандсан хэмээн ажилчдад зүй бус харьцахыг хориглодог.

Бүх аж ахуйн нэгжүүдэд дарамт шахалтаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээ авахыг шаарддаг!

Дэлгэрэнгүйг доорх линкээс үзнэ үү.

1. Байгууллагын чиг баримтлалыг тодорхойлох, түүнийг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх
2. Зөвлөгөө, хүсэлт (гомдлуудыг оруулаад)-нд зохих ёсоор хариу өгөх, шаардлагатай тогтолцоог бүрдүүлэх
3. Зөвлөгөө, хүсэлтийг хүлээж авсны дараа шуурхай, зохих хариу арга хэмжээ авах
4. Дарамтлалын шалтгаан, суурь хүчин зүйлийг арилгах арга хэмжээ авах
5. (Хувийн нууцыг хамгаалах г.м.) хамтад нь арга хэмжээ авах

■ Товхимол (Япон хэлээр) *Хуудас 20-иас хойш:

<https://www.mhlw.go.jp/content/11900000/001019259.pdf>

■ Ажлын байрны таатай орчин бүрдүүлэхийг дэмжих баг:

https://www.no-harassment.mhlw.go.jp/foreign_workers_jp



Зөвлөгөө авах газруудын жагсаалт



Зөвлөгөө өгөх газар: Нийслэл, мужийн Хөдөлмөрийн товчооны Жендэрийн эрх тэгш байдлыг хангах алба/тасгуудын холбоо барих утас (зөвлөхөд үнэ төлбөргүй)

Нийслэл, мужууд	Утасны дугаар	Нийслэл, мужууд	Утасны дугаар	Нийслэл, мужууд	Утасны дугаар	Нийслэл, мужууд	Утасны дугаар
Хоккайдо	011-709-2715	Токио	03-3512-1611	Шига	077-523-1190	Кагава	087-811-8924
Аомори	017-734-4211	Канагава	045-211-7380	Киото	075-241-3212	Эхимэ	089-935-5222
Иватэ	019-604-3010	Ниигата	025-288-3511	Осака	06-6941-8940	Коочи	088-885-6041
Мияги	022-299-8844	Тояма	076-432-2740	Хиого	078-367-0820	Фүкүока	092-411-4894
Акита	018-862-6684	Ишикава	076-265-4429	Нара	0742-32-0210	Сага	0952-32-7218
Ямагата	023-624-8228	Фүкүи	0776-22-3947	Вакаяма	073-488-1170	Нагасаки	095-801-0050
Фүкүшима	024-536-4609	Яманаши	055-225-2851	Тоттори	0857-29-1709	Күмамото	096-352-3865
Ибараки	029-277-8295	Нагано	026-227-0125	Шиманэ	0852-31-1161	Ойта	097-532-4025
Точиги	028-633-2795	Гифү	058-245-1550	Окаяма	086-225-2017	Миязаки	0985-38-8821
Гүнма	027-896-4739	Шизүока	054-252-5310	Хирошима	082-221-9247	Кагошима	099-223-8239
Сайтама	048-600-6269	Айчи	052-857-0312	Ямагүчи	083-995-0390	Окинава	098-868-4380
Чиба	043-221-2307	Миэ	059-226-2318	Токушима	088-652-2718		

Зөвлөх цаг: 8:30-17:15 (Бямба, ням, баярын өдрүүд, жилийн эцсийн болон эхний амралтын өдрүүдээс бусад)

※ Заавар зөвлөгөөг япон хэл дээр утсаар өгдөг.

※ Та орчуулагчаар дамжуулан өөрийн биеэр холбогдож зөвлөгөө авах боломжтой.

【Лавлагаа】 Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн тойм



Англи хэл



Хятад хэл



Португал хэл



Вьетнам хэл



Япон хэл